



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,  
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2025.03.11 № 1 / 805  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хариу хүргүүлэх тухай

Таны 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/772 дугаар албан бичиг, ЗГХЭГ-ийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ХЭГ/395 дугаар албан бичгээр ирүүлсэн Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн дагуу дараах хэм хэмжээний актуудыг тус Хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хүчингүй болгож шийдвэрлэлээ. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааны багц дүрэм”;

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”;

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 275 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”;

4. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”;

5. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”;

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 555 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”;

7. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 587 дугаар тогтоолоор баталсан “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр, тооцоо хийх ерөнхий журам”;

8. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 632 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”;

9. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 657 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам” зэрэг болно.

E:\ajil-2025\2025-A4.docx

1518000976

Харин дээрх албан бичигт дурдсан Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19, 2022 оны 360, 2024 оны 587, 648 дугаар тогтоолуудаар баталсан хэм хэмжээний актуудын талаарх тайлбарыг хавсралтаар хүргүүллээ.

Хавсралт: 11 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ



Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны  
03 дугаар сарын 1-ны өдрийн  
дугаар албан бичгийн хавсралт

1/806...

Handwritten signature and date in red ink.

ГҮЗ2072 9026030255 5043239

## ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛААГУЙ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТУУДЫН ТАЛААР

### ТАЙЛБАР

Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн бирж дээр арилжина" гэж заасан байдаг. Монгол Улсын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй 30 орчим компани нь гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй байна. Иймд хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс эдгээр компаниуд нь дотоодын хөрөнгийн бирж дээр өөрийн хувьцаагаа гаргах үүрэгтэй юм. Иймээс хувьцааны давхар бүртгэлийн орчинг бүрдүүлэх зорилгоор Хорооноос 2017 оны 151 тоот тогтоолоор Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчийн бүртгүүлсэн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагууд болох дэлхийд тэргүүлэгч 26 биржийн түр жагсаалтыг баталсан. Энэхүү жагсаалт батлагдсанаар Ашигт малтмалын тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангахын зэрэгцээ гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компани Монгол Улсын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлэхэд тавигдах бүртгэлийн шаардлагыг тодорхойлох, бүртгэлийн журам боловсруулах зэрэг нарийвчилсан зохицуулалтын орчинг бүрдүүлэх шаардлагатай болсон.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.2-т "Энэ хуулийн 17.1-д заасан компани гадаад улсад үнэт цаас гаргахдаа Хороонд бүртгүүлэх бөгөөд бүртгэлийн журмыг Хороо тогтооно", 18 дугаар зүйлийн 18.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 18.1-д заасан үнэт цаас гаргагчийн дагаж мөрдөх дүрэм, журмыг Хороо тогтооно", 18.4-т "Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчид тавих шалгуур, гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын жагсаалтыг Хороо тогтооно" гэж тус тус заасны дагуу "Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компани гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам"-ыг баталсан. Тус журам батлагдсаны үр дүнд 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Канад Улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй "Эрдэнэ ресурс деवलпмент корпораци" ХК нь үнэт цаасаа "Монголын хөрөнгийн бирж" ХК-д бүртгүүлж, анхны давхар бүртгэлтэй компани болсон. "Эрдэнэ ресурс деवलпмент корпораци" ХК нь өөрийн үнэт цаасыг Монгол Улсад давхар бүртгүүлэх үйл ажиллагааны хүрээнд 4,000,000 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган "Монголын хөрөнгийн бирж" ХК дээр анхдагч зах зээлийн арилжаанд оруулсан ба өнөөгийн байдлаар нийт 362 сая ширхэг энгийн хувьцаатай, зах зээлийн үнэлгээ 662 тэрбум орчим төгрөгт хүрсэн байна.

Тус хэм хэмжээний актын хувьд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой ямарваа нэгэн зөвшөөрөл, бүртгэлийн шинж агуулсан зохицуулалт тусгагдаагүй гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад үнэт цаас гаргах (үнэт цаасны давхар бүртгэл)-тай холбоотой хэм хэмжээний акт тул зохицуулалтын шинж байдлын хувьд зөвшөөрөл олгоход тавих шаардлага, процесс агуулаагүй ба хүчингүй болгох тохиолдолд Монгол Улсын санхүү, хөрөнгийн зах зээл болон хөрөнгө оруулалтын орчинд тодорхой сөргөөр нөлөөлөх дараах үр дагаврын үүсэж болзошгүй байна Үнд:

1. Хөрөнгө оруулалтын боломж хязгаарлагдах: Гадаадын биржид бүртгэлтэй компани Монгол Улсад үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт хийх боломж хумигдана. Энэ нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд гаднаас орж ирэх хөрөнгийн урсгалыг бууруулж, дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төрөлжүүлэх боломжийг багасгах үр дагавартай. Түүнчлэн, Монгол Улсад бүртгэлтэй компаниудын хувьд гадаад зах зээлд үнэт цаас гаргах процесс тодорхой бус болж, олон улсын хөрөнгө босгох боломж хязгаарлагдана. Энэ нь ялангуяа томоохон төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт татах гэж буй аж ахуйн нэгжүүдэд

№	Улсын бүртгэлийн дугаар	ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН НЭР
1	3836	Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19 дүгээр тогтоол)

		<p>сөргөөр нөлөөлнө.</p> <p>2. Зохицуулалтын тодорхой бус байдал: Журам хүчингүй болсноор хувьцааны давхар бүртгэлтэй холбоотой харилцаа нь хуулиар нарийвчлан зохицуулагдаагүй тул давхар бүртгэлийн зохицуулалтад тодорхой бус нөхцөл байдал үүснэ.</p> <p>3. Зах зээлийн хөгжил удаашрах: Монголын хөрөнгийн зах зээл олон улсын стандартад нийцэх, илүү өрсөлдөх чадвартай болох явц удааширна. Гадаадтай харилцах тодорхой журамгүй болсноор зах зээлийн интеграцлал, хөрвөх чадвар хязгаарлагдана.</p> <p>4. Эдийн засгийн боломж алдагдах: Гадаад зах зээлээс хөрөнгө татах боломж хумигдсанаар Монгол Улсын компанудын өсөлт, томоохон төслүүдийн санхүүжилт хойшлогдоно. Энэ нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж, ажлын байр бий болгох, экспортыг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдах.</p>
2	<p>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 360 дугаар тогтоол)</p>	<p>Зөвшөөрлийн тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үйл ажиллагаанд оролцогч талууд болох хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч, орон сууц санхүүжилтийн корпораци нь Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай. Гэвч эдгээр санхүүгийн нарийн мэргэшсэн, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдүүд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авахад тавигдах нөхцөл, шаардлага болон түүнийг нотлон ирүүлэх баримт бичгүүд, үйл ажиллагаанд тавигдах нарийвчилсан шаардлагыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд тусгаагүй байдаг. Харин хуульд зөвшөөрлийн шаардлагыг Санхүүгийн зохицуулах хорооны журмаар тогтоохоор заасны дагуу тус хэм хэмжээний актыг баталсан. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд эдгээр үйл ажиллагааны зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлагыг тусгаагүй байхад уг журмыг хүчингүй болгосон тохиолдолд дээрх этгээдүүд нь зөвхөн Зөвшөөрлийн тухай хуульд заасан ерөнхий нөхцлийг хангасан тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлийг олгох, улмаар тус санхүүгийн үйл ажиллагааг шууд эрхлэх нөхцөл байдал үүсэж байна. Олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад зөвхөн үнэт цаас гаргагчаас гадна олон талын оролцогчид оролцдог, зээл, түрээс, авлага зэрэг хөрөнгийг багцлан үнэт цаасжуулах ажиллагаа хийгддэг, багц хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдагч гүйцэтгэхийн зэрэгцээ санхүү, хөрөнгө оруулалтын мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага шаарддаг. Өөрөөр хэлбэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааг эрхлэх этгээд үйл ажиллагааны онцлогтой холбоотой нөхцөл, шаардлагыг хангаж, санхүү, хүний нөөцийн хувьд чадавхажсан, санхүүгийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэхүйц чадвартай байх шаардлагатай ба ингэснээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, оруулсан хөрөнгийг нь найдвартай удирдах боломж бүрдүүлж, эрсдэлийг бууруулдаг.</p> <p>Иймд энэ төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөлтэй оролцогчид нь хүний нөөцийн буюу үйл ажиллагаа эрхлэн явуулах мэргэшсэн боловсон хүчинтэй, тухайн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэл, хяналтыг хийх, нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлийг бүрдүүлсэн этгээд эрхлэх шаардлага анхнаасаа тавигддагаараа онцлог юм.</p> <p>Үүнтэй адил хөрөнгийн багцын бүртгэлийн хянагч буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өөр нэгэн төрөл болох барьцааг үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийн хянагчийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад мэргэшсэн байх шаардлага байдаг тул салбарын хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хүртэл түр хугацаанд хүчингүй болгохгүй байх зэрэгцээ шаардлага үүсээд байна.</p>
3	<p>Журам батлах тухай "Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам" (Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 648 дугаар тогтоол)</p>	<p>Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх харилцааг зохицуулсан салбарын хууль байхгүй. Харин уг харилцааг зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд журам баглан зохицуулахаар заасан тул хуулийг хэрэгжүүлж тус Хорооноос Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журмыг багцлан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу "саарал жагсаалт"-д оруулж, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянаж зохицуулагдаагүй, мөнгө угаах эрсдэлд өртөх өндөр эрсдэлтэй зэргээс шалтгаалан дээрх салбарт үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг бүртгэлжүүлэх, тусгай зөвшөөрөл олгож, хянаж зохицуулах үүрэг даалгавар өгсөн.</p> <p>Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээг авах байгууллага (ФАТФ)-ын саарал жагсаалтад орсонтой холбоотойгоор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мөрдөх техникийн 40 зөвлөмжийн хүрээнд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын</p>

	<p>байгууллагыг бүртгэлжүүлэх, хянах тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл олгох асуудлыг журам баглан хэрэгжүүлэхээр заасны дагуу холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын хяналт, зохицуултыг хэрэгжүүлэхээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагчийн 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 4737 тоот дүгнэлтээр Хорооны зохицуулалтад хамрагдаагүй 6,728 хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлээс үл хөдлөх эд хөрөнгийн худалдаа түрээс зэрэг үйл ажиллагааны чиглэлүүдийг хасуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p> <p>Монгол Улсад 2024 оныг дуусгах хугацаанд 312 хуулийн этгээлд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон бөгөөд дээрх хуулийн этгээдүүд нь 465 хувьцаа эзэмшигчдийн 7.3 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 30.0 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашигтай, 224.6 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна. Зуучлалын байгууллагууд нь зөвхөн 2024 онд 1.8 сая м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг 2.9 их наяд төгрөгөөр худалдах худалдан авах үйл ажиллагаанд зуучилсан бол 659.2 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг 234.9 тэрбум төгрөгөөр хөдөлүүлж, түрээслүүлэх үйл ажиллагаанд зуучилсан байна.</p> <p>Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас олон улсын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мөрдөх техникийн 40 зөвлөмжийн үнэлгээг сайжруулах чиглэлээр шуурхай арга хэмжээ авсны үр дүнд 2024 оны байдлаар ФАТФ-ын зөвлөмжийг бүрэн хангасан дэлхийн 5 дахь, ази, номхон далайн бүс нутгийн хэмжээнд анхны орон болсон нь Монгол Улсад үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын эрх зүйн орчныг бий болгон холбогдох шаардлагыг хууль тогтоомжид тусгаж, зохицуулалтыг боловсронгуй бий болгосныг олон улсаас баталгаажуулж буй явдал юм.</p> <p>Мөнгө угаах эрсдэлд өртөх өндөр эрсдэлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарыг зохицуулж буй дээрх журмыг салбарын зохицуулах хууль баталдаагүй байхад хүчингүй болгосноор Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-аас 2027-2028 оны хооронд хийгдэхээр төлөвлөгдсөн Монгол Улсын дараагийн шагна харилцан үнэлгээнд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж болзошгүй юм.</p>
<p>4</p> <p>7014</p>	<p>Журам багтах тухай “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаанд нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд журмын шинэчилсэн төслийг боловсруулахдаа Зөвшөөрлийн зөвлөлийн дүгнэлтэд нийцүүлэх арга хэмжээг авсан бөгөөд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны идэвх сул, арилжаа тогтворгүй байгаа энэ цаг үед Хорооноос баталсан холбогдох журмыг хүчингүй болгох нь биржийн үйл ажиллагаанд шууд бусаар сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзэн Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтэд хэлэлцүүлэх зэрэг хуульд заасан хугацаа, шаардлагыг хангуулах арга хэмжээг авч дараагийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхээр ажиллаж байна.</p>



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот


### Тогтоол хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/772 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм” батлах тухай 2019 оны 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

1518000124



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

### Тогтоол хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 14 дүгээр зүйлийн 14.5, 14.8, 14.11, 19 дүгээр зүйлийн 19.3, 22 дугаар зүйлийн 22.5, 31 дүгээр зүйлийн 31.3, 42 дугаар зүйлийн 42.2, 43 дугаар зүйлийн 43.3, 55 дугаар зүйлийн 55.1.2, 55.1.9, Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/772 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам” батлах тухай 2022 оны 275 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ



1518000126



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот


Тогтоол хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2, 55.1.12, Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/772 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” батлах тухай 2022 оны 276 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

1518000127



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот


### Тогтоол хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, сангийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага, түүнд хяналт тавих журам”, “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх журам” батлах тухай 2024 оны 630 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

1518000128



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот


Тогтоол хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/772 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Даатгалын багц дүрэм”-ийг шинэчлэн батлах тухай 2024 оны 632 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

1518000130



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 64


Улаанбаатар хот

### Тогтоол хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.1, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 14 дүгээр зүйлийн 14.6, Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/772 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг батлах тухай 2022 оны 160, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”, “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарь” батлах тухай 2024 оны 555 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.



1518000132



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот


### Тогтоол хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 15 дугаар зүйлийн 15.2, Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/772 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага” батлах тухай 2023 оны 384 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Г.ЖАМБААЖАМЦ

1518000137



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот


### Тогтоол хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1, Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/772 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам” батлах тухай 2024 оны 657 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

1518000138